

**СУМЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ 2025 ОНЫ ҮНДСЭН
ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ, 2026 ОНЫ ЗОРИЛТ**

2025.11.25

Булган аймаг Дашинчилэн сум

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрсэн түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь /хэрэгжилт/
			2024	2025	2026	
ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ						
76.1%						
1	Дотоодын нийт бүтээгдэхүүн	Тэрбум төгрөг	13262.2	15607.9	1859.7	2025 оны гүйцэтгэлээр ДНБ 15,607.9 сая төгрөгт хүрч, өмнөх оноос 2,345.7 сая төгрөг буюу 17%-иар өссөн байна. Сумын хэмжээнд 1,447.9 тонн мах, 33.2 тн ноолуур, 1 065.7 тн сүү, 113.2 тонн ноос, 13,296 ш арьс ширийг үйлдвэрлэж, арьс шир-52.2%, ноолуур-0.7%-иар тус тус буурсан байна. Сумын хэмжээнд газар тариалангийн үйл ажиллагаа эрхэлдэг Өрхтий трейд ХХК нь 270 тн улаанбуудай, 200 тн рапс борлуулсан байна. Сумын нэгдсэн ногооны талбайд болон өрхийн тариалан эрхлэгчид 22.3 тн төмс, 15.3 тн хүнсний ногоо, "Сорог төгөл" ХХК нь 28.1 га талбайгаас 15 тн чацаргана хураан авсан байна.
						Хэрэгжилт 90%
2	Нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн	Сая төгрөг	4.5	5.4	6.4	Нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн 5.4 сая төгрөг болж, өмнөх онтой харьцуулахад 20 хувиар өссөн түвшинд байна.
						Хэрэгжилт 90%

3	Төсвийн орлого	Сая төгрөг	613.7	2 451	3.415	2025 онд 3,064,128.1 мян төгрөгний төсөв батлагдсан. Үүнээс татварын орлого 696,575.3 төгрөг батлагдсанаас 11-р сарын байдлаар 626,918 төгрөг буюу 90 хувь, татварын бус орлого 33,000.0 төгрөг батласнаас 53,460 төгрөг буюу 162 хувь, санхүүгийн дэмжлэг 1,198,142.3 төгрөг батлагдсанаас 982,477 төгрөг буюу 82 хувь, ОНХС-н шилжүүлэг 593,274.7 мян төгрөг батлагдсанаас 416,479 төгрөг буюу 70.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Хүлээгдэж буй гүйцэтгэлээр татварын орлого 100% биелэхээр байна. Хэрэгжилт 100%
4	Төсвийн зардал	Сая төгрөг	1388.6	2 742	3.415	2025 онд төсвийн зарлага 3,064,128.1 мян төг батлагдсанаас 11 дүгээр сарын байдлаар 2,742,150 мянган төгрөг зарцуулагдаж, одоогийн байдлаар 89.5 хувийн гүйцэтгэлтэй байна. Хэрэгжилт 90%
5	Шинээр бий болгосон ажлын байрны тоо	тоо	102	167	150	Сумын хэмжээнд шинэ ажлын байранд 66 иргэн бүртгэхээс 72 иргэн, байнгын ажлын байранд 61 иргэн, улирлын ажлын байранд 1 иргэн, түр ажлын байранд 10 иргэнийг бүртгэснээс мал аж ахуйн чиглэлээр-10, газар тариалангийн чиглэлээр-8, барилга байгууламжийн чиглэлээр-15, худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр-21, бусад чиглэлээр-18 иргэн тус тус ажлын байраар хангагдсан ба нийт 167 ажлын байр бий болж өмнөх оноос 16%-иар өссөн үзүүлэлттэй байна. Мөн ажилд зуучлах үйлчилгээнд 95 иргэнийг бүртгэсэн байна. Хэрэгжилт 100%

6	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төвлөрүүлэлтийн хувь	Хувь	70	70	75	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн ажлын байрыг дэмжих хөтөлбөрт хамрагдсан 3 иргэн 9.2 сая, малжуулах хөтөлбөрт хамрагдсан 8 өрх 14 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан 2 иргэн 3.7 сая, ахмадын ажлын байрыг дэмжих төсөлд хамрагдсан 4 иргэн 4.4 сая төгрөгийг тус тус төлж, нийт 31.3 сая төгрөгийг тус санд төвлөрүүлсэн байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн эргэн төвлөрүүлэлт 70% байна Энэ нь өмнөх оноос 3%-аар өсч зээлийн гэрээний дагуу төлөлтүүд хэвийн хийгдэж байна.	Хэрэгжилт 100%
7	Ажилгүйдлийн түвшин	Хувь	18	14	13	Сумын хэмжээнд ажил хөдөлмөр эрхлэх чадвартай хөдөлмөрийн насны 1536 иргэн байгаагаас 1305 иргэн ажил хөдөлмөр эрхэлж байна. Сумын ажилгүйдлийн түвшинг аргачлалын дагуу тооцож үзэхэд 1.4% байна. Ажилгүйдлийн түвшин өмнөх оноос 0.4%-аар буурсан дүнтэй байна.	Хэрэгжилт 70%
8	Ажиллах хүчний оролцооны хувь	Хувь	18	19	2	2025 онд хөдөлмөрийн зах зээлийн программд ажил хайгчаар 105 иргэн бүртүүлсэнээс байнгын ажлын байранд-85, түр ажлын байранд-10, идэвхитэй ажил хайсан-10 иргэн байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас энэ онд ажлын байрыг дэмжих төсөл хөтөлбөрт 1 иргэн 9 сая, ахмадын ажлын байрыг дэмжих төсөл хөтөлбөрт 4 иргэн 30 сая, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 4 малчин 32 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих төсөл хөтөлбөрт 2 иргэн 17 сая төгрөгний санхүүжилтийг тус тус авсан байна. Нийт 11 иргэнийг 88 сая төгрөгний хөнгөлттэй зээлд хамруулсан байна. Ажиллах хүчний оролцоо 0.1%-иар өссөн.	Хэрэгжилт 90%

9	Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн нийт хүн амд эзлэх хувь	Хувь	60	80	80	Эрүүл мэндийн даатгалыг 2024 оноос e-baimt-р төлдөг болсон. Иргэдэд эрүүл мэндийн даатгалыг цахимаар төлөх зааврыг тухай бүрт нь мэдээллийг хүргэж, заавар зөвлөгөө өгч ажиллаж байна. Сумын хэмжээнд 0-19 настай хүүхдүүд, тэтгэврийн насны иргэд, хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэвэр авагчид, амьжиргааны түвшин 600-с доош оноотой өрхийн иргэдийн эрүүл мэндийн даатгалыг төрөөс хариуцдаг. Мөн хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийг ЭМД-ийг албан журмын даатгалд хамруулан төлүүлж байна. Хэрэгжилт 80%
10	Эдийн засгийн идэвхитэй хүн ам /ажиллах хүч/-ын нийгмийн даатгалд эзлэх хувь	Хувь	60	60	65	Эдийн засгийн идэвхитэй хүн ам болох 1415 иргэнээс 357 иргэн хамрагдсан ба үүнээс шинээр сайн дурын даатгалд 196, ААНБ-ийн даатгалд 161 иргэн тус тус хамрагдсан. Малчдын сайн дурын даатгалд шинээр 210 малчин хамрагдсан. 2025 онд багийн иргэдийн нийтийн хурлуудаар дамжуулан малчдад нийгмийн даатгалын ашиг тусыг ойлгуулан сурталчилах ажлыг зохион байгуулсан. Хэрэгжилт 60%
11	Шинээр бий болгосон байнгын ажлын байрны тоо	Тоо	57	72	65	Сумын хэмжээнд 2025 онд шинээр бий болсон ажлын байр 72 үүнээс байнгын-61, улирлын-1, түр-10 ажлын байр тус тус бүртгэсэн. Үүнээс мал аж ахуйн чиглэлээр-10, газар тариалангийн чиглэлээр-8, барилга байгууламжийн чиглэлээр-15, худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр-21, бусад чиглэлээр-18 иргэн тус тус ажлын байраар хангагдаж, нийт 72 байнгын ажлын байр шинээр бий болж өмнөх оноос 13.2%-иар өссөн үзүүлэлттэй байна. Хэрэгжилт 100%
12	Малын тоо	Мянган толгой	134874	171090	-	Адуу-15068, үхэр-13932, тэмээ-80, хонь-75530, ямаа-66480, нийт 171090 толгой мал тоологдож, өмнөх оноос 175 толгой малаар өссөн үзүүлэлттэй байна. Хэрэгжилт 90%
13	Хураан авсан үр тариа	Мянган тонн	1075	270	800	Улаан буудай 858 га-аас 270 тн, рапс 780 га-с 200 тн хураан авсан ба ургац алдалтын хувь өндөр байна. Хэрэгжилт 50%

14	Хураан авсан малын тэжээл	Мянган тонн	90	20	20	2025 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангах ажлын хүрээнд 20 тн малын тэжээл хураан авсан. Хэрэгжилт 70%
15	Хураан авсан төмс, хүнсний ногоо	Мянган тонн	32.6	37.6	43	Энэ онд өрхийн тариалан эрхлэгч 30 иргэн 7.28 га талбайгаас 22.3 тн төмс, 5.4 га талбайгаас 15.3 тн хүнсний ногоо тус тус хураан авч, өмнөх оноос төмс, хүнсний ногоог 5 тн-р илүү хураан авсан үзүүлэлтэй байна Хэрэгжилт 80%
16	Хүлээн авах гадаад жуулчдын тоо	Тоо	50	50	70	2025 онд 90 дотоодын жуулчин, 50 гадаадын жуулчин нийт 140 жуулчин хүлээн авсан ба жилээс жилд дотоод, гадаадын жуулчдын тоо нэмэгдсээр бна. Энэ онд "Хар бүх музей"-н танилцуулга, хаяг бүхий самбар болон ариун цэврийн байгууламжийг шинэчлэсэн. Хэрэгжилт 80%
17	Идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын тоо	Тоо	60	48	60	Сумын хэмжээнд төрийн байгууллага 6, хариуцлагатай хувьцаат компани 47, хоршоо 61, холбоо 6, нөхөрлөл 3, хэвлэл мэдээллийн байгууллага 1, шашны байгууллага 1, нийт 125 аж ахуй нэгж байгууллага бүртгэлтэй байна. Үүнээс 48 буюу 38.4%-ийг идэвхитэй үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуй нэгж, байгууллага эзэлж байна. Идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагын тоо өмнөх оноос 12-оор буурсан байна. Хэрэгжилт 50%
18	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь	Хувь	74.7	75.4	77	Сумын хэмжээнд 6 албан байгууллага, 57 ААН, 681 айл өрх цахилгаан эрчим хүчинд хамрагдсан ба нийт хүн амын 75.4%-ийг эзэлж байна. Хэрэгжилт 80%
НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ						94%

19	Бүртгэгдсэн гэмт хэрэг	Тоо	5	8	6	2025 онд нийт гэмт хэргийн шинжтэй 8 гомдол мэдээлэл бүртгэгдэж шалгагдсанаас мал хулгайлах 2 хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 3, болгоомжгүйгээр бусдын эд хөрөнгө устгаж гэмтээх 1 гэмт хэргийн шинжгүй нөхцөл байдал тогтоогдсон. Мөн 2 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж шийдвэрлэсэн. Хэрэгжилт 70%
20	Иргэдэд учирсан хохирлын нөхөн төлүүлэлтийн түвшин	Хувь	80	70	80	Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлж, таслан зогсоох чиг үүргийн дагуу сумын хэмжээнд нийт 32 гомдол, мэдээллийг шалган шийдвэрлэн, шүүхийн байгууллагад хүргүүлсэн. Сумын хэмжээнд иргэдэд учирсан хохирлын нөхөн төлүүлэлтийн түвшин 70%-тай байна. Хэрэгжилт 70%
21	1 000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин	Промиль	0	0	0	2025 онд нийт 23 эх төрж, эх нялхсын эндэгдэлгүй ажилласан ба эндэгдлийн түвшин 0% байна. Хэрэгжилт 100%
22	10 000 хүн амд вирус гепатитын өвчлөл	Тоо	85	100	100	2025 онд эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд 1075 иргэн хамрагдахаас 850 иргэн хамрагдсан. 2025 онд вирус гепатитын тохиолдол бүртгэгдээгүй. Сумын эрүүл мэндийн төвд С. Дельта вирустай 183 иргэн эмчийн хяналтанд байна. Энэ онд элэгний хорт хавдраар 2 иргэн оношлогдож, хавдар судлалын үндэсний төвд химийн эмчилгээ хийлгэн, хяналтад байна. 10000 хүн амд харьцуулахад вирус гепатитын өвчлөл 620 промилль байна. Хэрэгжилт 100%

23	Тухайн жилийн товлолт дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь	Хувь	100	100	100	2025 онд товлолт дархлаажуулалтанд 404 хүүхэд хамрагдахаас давхардсан тоогоор 641 хүүхэд хамрагдаж, хамрагдалтын хувь 100%-тай байна. Саагийн вакцинд 74 хүүхэд, Тавт вакцинд 74 хүүхэд, Пэв вакцинд-110 хүүхэд, УГУ вакцинд -105 хүүхэд, А гепатит вакцинд -94 хүүхэд, тарьдаг саагийн вакцинд-30 хүүхэд, сахуу татрангийн вакцинд-78 хүүхэд, хүний папилимо вируссын вакцинд-76 хүүхэд тус тус хамрагдсан байна.	Хэрэгжилт 100%
24	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь	Хувь	100	100	100.0	Артерийн гипертензийн үзлэгт 1854 иргэн хамрагдахаас 1854 иргэн хамрагдаж хамрагдалтын хувь 100%-тай байна.	Хэрэгжилт 100%
25	Чихрийн шижин өвчний үеийн эрт илрүүлгийн хамралтын хувь	Хувь	100	100	100.0	Чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэгт 1256 иргэн хамрагдахаас 1256 иргэнийг 100% хамруулсан. 2025 онд чихрийн шижин өвчний хяналтанд 36 иргэн байна.	Хэрэгжилт 100%
26	Хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь	Хувь	95	100	100	Хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт 497 эмэгтэй хамрагдахаас 505 эмэгтэй хамрагдаж хамрагдалтын хувь 101.6%, умайн хүзүүний өмөнгийн үзлэгт 242 эмэгтэй хамрагдахаас 162 эмэгтэй хамрагдаж хамрагдалтын хувь 66.9%, 40 дээш насны хавдрын эрт илрүүлэгт 1075 иргэн хамрагдахаас 850 иргэн хамрагдаж хамрагдалтын хувь 79%-тай байна. Эрт илрүүлгийн үзлэгээр шинээр оношлогдсон хавдарын 6 тохиолдол бүртгэгдсэн. Үүнд: хүзүүний хавдар-1, Шодойн хавдар-1, Уушигны хавдар-1, Хөхний хавдар-1, Элэгний хавдар-2, тус тус оношлогдон химийн эмчилгээ болон эмийн эмчилгээнд хамрагдаж байна.	Хэрэгжилт 100%

7	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт	Тоо	100	152	150	2025-2026 онд цэцэрлэгийн бүртгэл мэдээлэлийн системд 2-5 насны нийт 228 хүүхэд бүртгэгдсэнээс байнгын бүлэгт 152 хүүхэд, хувилбарт сургалтанд 76 хүүхэд хамрагдаж байна. Байнгын бүлэгт нийт 152 хүүхэд бүртгүүлснээс одоогоор тогтмол 145 хүүхэд хамрагдаж, СӨБ-н хамран сургалтын хувь 94%-тай байна. Хэрэгжилт 100%
28	Суурь боловсролын хамран сургалт	Тоо	633	525	528	Ерөнхий боловсролын сургуулийн бага ангид 278 сурагч, дунд ангид 245 сурагч, ахлах ангид 116 сурагч буюу нийт 639 сурагч суралцаж байна. Суурь боловсролын хамран сургалтад 1-9-р ангийн 525 сурагч хамрагдаж байна. Хэрэгжилт 100%
29	Цэцэрлэгийн бүлгийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	Тоо	25+5	30+5	25+5	Цэцэрлэгийн 1 бүлэгт 30+5 хүүхэд бүртгэн авах нормтой ба 5 бүлэгт нийтдээ 152 хүүхэд буюу 1 багшид 30-35 хүүхэд ноогдож байна. 2025-2026 оны хичээлийн жилд цэцэрлэгийн байнгын бүлэгт бүртгүүлж чадаагүй буюу хувилбарт сургалтын хүүхэд 76 байна. Эдгээр хүүхдүүдэд зайны сургалтын материал, дасгал даалгаврын багц хүргэн ажиллаж байна. Цаашид цэцэрлэгийн барилгын өргөтгөл шийдэгдэх юм бол 1-2 бүлэг нэмэн ажиллах бүрэн боломжтой. Үүний үр дүнд сургуулийн өмнөх боловсролыг хүүхэд бүрт хүртээлтэй хүргэж ажиллах боломж бүрдэж, хувилбарт сургалтын хүүхэд багасна. Хэрэгжилт 100%
30	Бага ангийн нэг багшид ногдох хүүхдийн тоо	Тоо	29	30+5	30	Ерөнхий боловсролын сургууль нь бага ангийн 11 бүлэгтэй. 1-р ангид 53, 2-р ангид 51, 3-р ангид 52, 4-р ангид 62, 5-р ангид 61 сурагцагч тус тус суралцаж байна. Өмнөх хичээлийн жилээс нэг багшид ногдох хүүхдийн тоо 3-аар багассан. 1 багшид 26 сурагч ногдож байна. Анги дүүргэлт нь иргэдийн шилжилт хөдөлгөөн, хүн амын өсөлттэй холбоотойгоор өөрчлөгдөж байдаг. 3 жилийн урьдчилсан тоон судалгаагаар анги дүүргэлтийн тоо 35-аас хэтрэхгүй байхаар байна. Хэрэгжилт 100%

31	Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо	Тоо	503	507	515	2025 оны элсэлтийн шалгалтанд төгсөх ангийн 32 хүүхэд 8 судлагдахуунаар оролцсоноос сурагчдын дундаж оноо 507 болж өмнөх оноос 4 оноогоор ахисан үзүүлэлттэй байна. Хэрэгжилт 80%
32	Төрийн цахим үйлчилгээний тоо	Тоо	153	600	600	Төрийн үйлчилгээг иргэдэд хурдан шуурхай хүргэх зорилгоор "Хурдан" системийг нэвтрүүлж 24-н цагийн ажиллагаатай КИОСК машиныг ажиллуулж, ажлын 8-н цагт E-mongolia-аас лавлагаа тодорхойлолтыг энэ онд давхардсан тоогоор 720 гаруй иргэнд олгож ажилласан байна. Иргэд КИОСК машинаас 60 байгууллагын 600 үйлчилгээ авах боломж бүрдсэн байна. Мөн ил тод байлгах зорилгоор сумын цахим хуудас болон WEB хуудсаар цаг үеийн мэдээллийг хүргэн, энэ онд давхардсан тоогоор 8000 гаруй иргэнд мэдээллийг цахимаар хүргэсэн байна. Хэрэгжилт 100%

Дашинчилэн сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2 зорилтын 32 арга хэмжээ тухайн жилд 85.1% хувьтай хэрэгжлээ

ХҮНС, ЖДҮ, ХОРШООНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН *Гүл* Б.ОРХОН
 БИЕЛЭЛТ-ГАРГАСАН:
 ХЯНАСАН:
 ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ *M. Tanyulga* М ГАНТУЛГА

